



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Санхүү эдийн засгийн их сургууль

Хөтөлбөрийн нэр: Эрх зүй

Индекс: 042101

Шинжээчийн баг:

Ахлагч: С.Оюунбилэг
Гишүүд: Ш.Ариунбилэг
М.Сувд

Улаанбаатар хот
2021он

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	9
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	11
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	13
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	18
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	21
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	27
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	31
I. Багш нарын нэрс	31
II. Оюутнуудын нэрс	32
III. Ажил олгогчдын нэрс.....	33
IV. Төгсөгчдийн нэрс	33
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	34
VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

Товчилсон үгийн тайлбар

СЭЗИС	Санхүү эдийн засгийн их сургууль
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
ЭЗТ	Эрх зүйн тэнхим
БСА	Бакалаврын сургалтын алба
АТСА	Ахисан түвшний сургалтын алба
ИДС	Их, дээд сургууль
ЭЗХ	Эрх зүйн хөтөлбөр
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МЭХ	Мэргэжлийн зөвлөх хороо
ЭШХ	Эрдэм шинжилгээний хурал
БСС	Бакалаврын сургалт, судалгаа
ЭЗС	Эдийн засаг, санхүү
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
МУИС	Монгол Улсын Их сургууль
ХЗС	Хууль зүйн сургууль
ИЗИС	Их засаг их сургууль
ОТИС	Отгонтэнгэр их сургууль
ЭИС	Этүгэн их сургууль
ДХИС	Дотоод Хэргийн их сургууль
ШХИС	Шихихутуг их сургууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Санхүү эдийн засгийн их сургууль University of Finance and Economics	
Сургалтын хөтөлбөрийн нэр	Эрх зүй Law	
Индекс	042101	
Шинжээчид	<p>Шинжээчийн багийн ахлагч: С.Оюунбилэг - Шихихутуг их сургуулийн төгсөлтийн дараах сургалтын албаны дарга, ахлах багш</p> <p>Шинжээчийн багийн гишүүд: Ш.Ариунбилэг - Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн хувийн эрх зүйн тэнхмийн эрхлэгч, доктор М.Сувд - Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхмийн эрхлэгч, доктор</p>	
Мэргэжилтэн	Б.Мядагмаа – БМИУЗ-ийн Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2021-11-16 Мягмар гараг 09.00-11.00	БМИУЗ-ийн дэд дарга, Ажлын албаны захирал О.Янжмаа нээж, шинжээчийн багийг танилцуулах. Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах Шинжээчийн багийн ахлагч Удирдлага болон Өөрийн үнэлгээний багийн танилцуулга /СЭЗИС-ийн БСС хариуцсан проректор Б.Мөнхзаяа/ Сургуулийн танилцуулга /СЭЗИС-ийн ЭЗС хариуцсан проректор С.Бямбахорлоо/ Эрх зүй хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн товч танилцуулга /Өөрийн үнэлгээний багийн ахлагч Д.Оюун/
	11.00-12.00	Сургуулийн бэлтгэсэн илрэл, нотолгоотой танилцах
	12.00-13.00	Багш нартай хийх уулзалт
	14.00-15.00	Сургуулийн орчин нөхцөл, лаборатори, анги танхим, номын сантай танилцах
	15.00-16.00	Оюутнуудтай хийх уулзалт /цахим/
	16.00-16.30	Удирдлага мэдээллийн системийн танилцуулга хийх
	16.30-17.30	Шинжээчийн багийн уулзалт
	2021-11-17	09.00-10.00
	10.00-11.00	Ажил олгогчидтой хийх уулзалт /цахим/
	11.00-11.30	Шинжээчийн багийн уулзалт
	11.30-12.30	Төгсөгчидтэй хийх уулзалт
	12.30-15.00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	15.00-17.30	Шинжээчийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэх
Шалгуур шаардлага /журам/	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаарсарын 29-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан “Бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

СЭЗИС нь анх 1924 онд байгуулагдаж түүхэн хөгжлийн үе шатуудыг дамжсаар 2016 онд их сургуулийн статустай болсон. Монгол Улсын ууган сургуулиудын нэг СЭЗИС нь үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэлийн чанарын баталгааг хангасан үйл ажиллагааг явуулж БМИҮЗ-өөр байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд амжилттай хамрагдсаар ирсэн. Цаашилбал олон улсын магадлан итгэмжлэлд хамрагдаж анх 2008 онд АНУ-ын Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын байгууллага болох ACBSP /Америкийн Бизнесийн Сургууль Хөтөлбөрүүдийн Нэгдсэн Холбоо/ -д гишүүнээр элсэж, 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын их дээд сургуулиудаас анхдагч болон олон улсад магадлан итгэмжлэгдсэн. Эрх зүйн хөтөлбөрийг 2014 оноос БШУ-ны сайдын 2014 оны 5 сарын 14-ний өдрийн А/208 тоот тушаалаар эрх зүйн мэргэжлийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноор эрх зүйн бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийг Эрх зүйн тэнхим хэрэгжүүлж байгаа.

Эрх зүйн хөтөлбөрийн зорилгоо: Эрх зүйн шинжлэх ухааны онол арга зүй, олон улсын эрх зүй судлал, Монголын төр хууль цаазны түүхэн уламжлал, шинэчлэлд тулгуурласан, хүний хөгжлийг хангахуйц чанартай сургалт явуулж, эдийн засаг болон эрх зүйн мэдлэгийг оновчтой хослуулсан, мэргэжлээрээ өрсөлдөх чадвартай, эрх зүйч мэргэжлийн үнэт зүйлс, соёл төлөвшсөн мэргэжилтэн, судлаач бэлтгэхэд оршино гэж тодорхойлоод хөтөлбөрийн зорилгын хүрээнд суралцагчдад дараах мэдлэг, ур чадварыг хичээлийн түвшин бүрт олгох зорилт тавин ажилладаг.

“Эрх зүй” бакалаврын хөтөлбөрийн сургалтын зохион байгуулалтын үндсэн эрх зүйн баримт бичиг нь СЭЗИС-ийн “Бакалаврын сургалтын журам” бөгөөд сургалтын зохион байгуулалтын ажлыг Эрх зүйн тэнхим хариуцан хэрэгжүүлж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг боловсруулахдаа Монголын болон гадаадын эрдэмтэд, судлаачдын эрх зүйч мэргэжилтэн бэлтгэх талаарх үзэл баримтлалд үндэслэсэн.
- МУИС-ийн ХЗС, ИЗИС, ОТИС, ЭИС, ХСИС, ШХИС зэрэг их, дээд сургуулиудын эрх зүйн хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа хийж, давуу, сул талаа тодорхойлжээ. Харьцуулсан судалгааны үр дүнгээр дадлагын хичээлийн кредит бага боловч дадлага хийлгэх хугацаа нь ойролцоо байна, мэргэжлийн хичээлүүдийн агуулгын хувьд бусад сургуулийн эрх зүйн хөтөлбөртэй ижил төстэй байна гэсэн дүгнэлт хийсэн нь эрх зүй хөтөлбөрийн агуулга нь эрх зүйн боловсролын бакалаврын стандартад нийцэж байна гэх үндэслэлтэй.
- Гадаадын хэд хэдэн сургуулийн туршлага судалж, эрх зүйн хөтөлбөрүүдийн харьцуулсан судалгаа хийсэн. ХБНГУ, АНУ, Хонгконгийн хууль зүйн сургуулиудын эрх зүйн хөтөлбөрийг харьцуулан судалсны үр дүнд ХБНГУ-ын Франкфурт дахь Гёте Их сургуулийн эрх зүй хөтөлбөр, БНХАУ-ын Хонгконгийн их сургуулийн эрх зүй хөтөлбөрийн хөгжлийн жишгийг баримжаалан хэрэгжүүлэх боломжтой, АНУ-ын Нотр Дам их сургуулийн хэрэгжүүлдэг төгсөх ангийн оюутнуудад мэргэжлийн ур чадвар олгох, практик туршлага эзэмшүүлэх чиглэлийн хичээлийг хөтөлбөрт тусгах сайн туршлага гэж үзсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан хичээл сонгон судлах боломж олгосон.
- ЕАР англи хэлний хичээл судлах багц цагтай байгаа нь англи хэлний мэдлэгтэй эрх зүйч бэлтгэх боломжтой. Энэ нь эрх зүй мэргэжил манай улсад хамгийн эрэлттэй мэргэжлүүдийн нэг болж тооцогдож буй өнөө үед ялангуяа зах зээлийн эдийн засгийн үе дэх гадаад харилцааны хөгжлийн явцад гадаад хэлтэй эрх зүйч, хуульч нийгмийн эрэлт хэгэгцээг хангахад уг эрх зүй хөтөлбөрийн бүрэлдэхүүн ЕАР англи хэлний хичээл чухал ач холбогдолтой.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн залгамж холбоог алдагдуулахгүйгээр эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, бизнесийн эрх зүйн чиглэлээр мэргэшүүлэн бизнесийн эрх зүйч бэлтгэх онцлог, боломж, нөөцөө ашиглахад чиглүүлэн хөтөлбөрөө боловсронгуй болгоход анхаарах.

Зөвлөмж:

- Эрх зүйн хөтөлбөрийн дэд хороо байгуулж, хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлээ хийдэг тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилго, үндэслэлээ тодорхойлохдоо Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А174 тоот тушаал, СЭЗИС-ийн Ректорын тушаал, шийдвэрүүд, мөн бакалаврын хөтөлбөрийн зорилго (PEO) болон холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичигт үндэслэсэн.
- 2018, 2019 оны төгсөгчдөөс судалгаа авч, эрх зүйн хөтөлбөрийн зорилгод хүрч буй эсэх талаар дүн шинжилгээ хийж, хөтөлбөрөө шинэчлэн сайжруулах алхам хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрх зүй хөтөлбөрийн алсын хараагаа “эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, бизнесийн эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж чадах, өрсөлдөх чадвартай, хүнлэг, ёс суртахуунлаг эрх зүйч мэргэжилтэн бэлтгэдэг хөтөлбөр байна” хэмээн тодорхойлсон нь бизнесийн чиглэлийн мэргэшсэн эрх зүйч бэлтгэх хэтийн зорилготой онцлог байна.

Анхаарах асуудал:

- Бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх агуулга бүхий алсын харааг тодорхойлсонд үндэслэн “аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал, дижитал эриний бизнесийн орчинд ажиллах чадвартай, энтрепренер сэтгэлгээтэй, Монгол Улсын эдийн засаг, санхүү, нийгэм, эрх зүй, мэдээллийн технологийн орчинд тэргүүлэх байр суурьтай оролцдог, мэргэжлийн салбартаа манлайлагч, өндөр ёс зүйтэй иргэн бэлтгэнэ” гэж бакалаврын хөтөлбөрийн зорилгоо тодорхойлсон нь эрх зүйч мэргэжилтэн бэлтгэх үндсэн зорилготойгоо нийцүүлэн томъёолоход анхаарах нь зүйтэй.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхдээ Монгол Улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (1995, 2014), Дээд боловсролын тухай Монгол Улсын хууль, БСШУ-ны сайдын 2014 оны 4 сарын 28-ны өдрийн “Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрт тавигдах нийтлэг

шаардлага батлах тухай” А/174 тоот тушаал, БШУ-ны сайдын 2013 оны 3 сарын 18-ны өдрийн “Оюутан элсүүлэх журам батлах тухай” А/79 тоот тушаал, СЭЗИС-ийн Ректорын 2019 оны 4 сарын 18-ны өдрийн “Хөтөлбөрийн хорооны процесс батлах тухай” А/080 тоот тушаалын Хавсралт №2-оор батлагдсан “Хөтөлбөр боловсруулах, хэлэлцэх, батлах, процесс” зэрэг баримт бичигт үндэслэсэн.

- Эрх зүйн хөтөлбөрийн бүтэц, харьцаа нь (ерөнхий суурь хичээл, мэргэжлийн суурь, хичээл, мэргэжлийн хичээлийн кредит цаг) бакалаврын сургалтын хөтөлбөрийн шаардлагад нийцсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын бизнесийн хэлцэл, гэрээ байгуулах арга, тактик, олон улсын төслийн санхүүжилтийн эрх зүй, олон улсын худалдаа, өрсөлдөөний эрх зүй гэх мэт олон улсын бизнесийн эрх зүйн чиглэлийн хичээлүүдийг заавал суралцах олон сонголттой хичээл болгон судлах боломжтой байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн залгамж холбоог харгалзах замаар мэргэшсэн бизнесийн эрх зүйч бэлтгэхэд энэ чиглэлийн үндэсний эрх зүйн хичээлийг заавал судлах хичээл болгосныг үндэслэн олон улсын бизнесийн эрх зүйн хичээлүүдийг үргэлжлүүлэн судлах уялдаа холбоог хангах.

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөг жил бүр шинэчилсэн боловч уг өөрчлөлтийг хийхдээ нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг сайтар судлан, алсын хараа, хэтийн зорилгодоо чиглүүлэн хөтөлбөрийг шинэчлэх үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.
- Бизнесийн эрх зүйчээр мэргэшсэн эрх зүйч бэлтгэх бодлого баримтлах.
- Эдийн засгийн эрх зүй, банкны эрх зүй, санхүүгийн эрх зүй, үнэт цаасны эрх зүй, худалдааны эрх зүй гэх мэт салбар эрх зүйн хичээлүүдийг заавал судлах мэргэшүүлэх чиглэлийн хичээл болгон хөтөлбөрийн шинэчлэл хийх, мөн багшлах бүрэлдэхүүнийг эдгээр чиглэлээр хөгжүүлэх.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Эрх зүй хөтөлбөрөөр суралцагчдын эзэмших мэдлэг, ур чадварын суралцахуйн үр дүнгийн матрицыг тодорхойлсон.
- СЭЗИС-ийн Ректорын 2019 оны А/057 тоот тушаалаар баталсан “бакалаврын сургалт зохион байгуулах журам”-ын холбогдох заалтыг үндэслэн суралцагчдын ачааллыг тооцоолдог.
- Эрх зүй хөтөлбөрөөр суралцагчийн практик мэдлэг, чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн байгууллагатай хамтран ажилладаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрийн оюутнууд судлах хичээл болон багшийг оюутны Infosys программаар оюутан хичээл сонголт хийх боломжтой.
- Эрх зүй хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар 100 хувь хуульчийн эрхтэй байна.

Анхаарах асуудал:

- Нэгж хичээлийн хөтөлбөрийн агуулгыг анхаарах.

Зөвлөмж:

- Нэгж хичээлийн хөтөлбөрт тусгагдсан хичээлийн өмнөх болон дараах залгамж холбоог анхаарах.
- Үйлдвэрлэлийн мэргэжлийн дадлагын удирдамжийг боловсронгуй болгох.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- G-suite багц программ, Moodle цахим сургалтын удирдлагын системийг нэвтрүүлсэн.
- Багшийн заах арга зүй, багш, оюутны харилцаа, семинарын хичээлийн арга зүй гэх зэрэг сургалтын арга зүйг сайжруулах чиглэлээр хөндлөнгийн судалгаа авч, дүн шинжилгээ хийж хэвшсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Цахим сургалтын арга, хэлбэрийг орчин үеийн шийдэл бүхий цогц системийг СЭЗИС-ийн хүрээнд бүрдүүлэн хэрэгжүүлж байгаа нь эрх зүй хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд түлхэц болсон.
- Нэгж хичээлийн цахим сан бүрдсэн байна. Тухайлбал, видео хичээл, оюутантай уулзалт, хэлэлцүүлэг хийх, хичээлийн сургалтын материал, эх сурвалж, РР танилцуулга, семинарын удирдамж, оюутны бие даалтын ажил, сорил, шалгалтын материал гэх зэрэг бүрдэлтэй байсан.
- EBSCO цахим эх сурвалж ашиглах нөхцлийг бүрдүүлсэн.

Зөвлөмж:

- Эрх зүй хөтөлбөр хэрэгжүүлэгч багшлах бүрэлдэхүүн EBSCO цахим эх сурвалж ашиглалтыг нэмэгдүүлэх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн үнэлгээний бүтэц, интервалыг явцын шалгалт 30-40 оноо, бие даалтын оноо 20-30 оноо, семинар 10-15 оноо, гэрийн даалгавар 10-15 оноо буюу нийт 80 оноо, хүмүүжил, хандлагыг 20 оноогоор тус тус үнэлж 100 оноогоор үнэлгээг хийдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- BLFP431 кодтой 3 кредитын дипломын төслийн ажил бичдэг онцлогтой ба үүнийгээ номын санд байршуулсан нь судалгааны эх сурвалж болохуйц чанартай бичигдсэн байв.
- Суралцагчийн үнэлгээний 5 жилийн судалгааг гарган дүн шинжилгээ хийсэн байна.
- Хичээлүүдийн үнэлгээний рубриктэй (хичээлийн гарц үр дүнг үнэлэх үзүүлэлт, үнэлгээний блүүмийн таксаномын аргаар үнэлэх арга боловсруулсан)

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагч оюутны тоо нэмэгдэхийн хэрээр сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, анги танхимын хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага урган гардаг. Энэхүү шаардлагыг хангахын тулд А байрны өргөтгөлийг 1988 онд, В байрыг 2007 онд, С байрыг 2014 онд ашиглалтанд оруулж, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн тохижуулсан нь багшлахуй, суралцахуйн таатай орчинг бүрдүүлсэн байна.
- Сургалтын зориулалттай анги танхим, оюутны дотуур байр, номын сан, нийтийн хоолны үйлчилгээний цэг, биеийн тамирын заал нь эрүүл ахуй аюулгүй байдлын шаардлага хангасан, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш ажилтан, суралцагчдын хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн байна.
- Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг/ Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш ажилтан, суралцагчдын хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй аюулгүй байдлын шаардлага хангасан байна”, “Дээд боловсролын сургалтын байгууллагад тавигдах нийтлэг шаардлага”-д нийцэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Багш суралцагчдын хэрэгцээнд нийцсэн сургалт судалгааны танхим, лаборатори, хэрэглэгдэхүүнтэй байна. Тус сургуулийн анги танхимын 46% нь орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, анги танхим, лабораторийн үйл ажиллагааг хянан, шаардлагатай төхөөрөмжүүдээр шинэчилж ирсэн байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүний талаар Эрх зүйн хөтөлбөрийн суралцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгаагаар нийт суралцагчдын 75-89 хувь нь “хангалттай сайн” үнэлгээ өгсөн байна.
- “Хэрэглээний программ хангамж”, “Алгоритм програмчлал” хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнд тусгаж өгсөн нь ажил олгогчдын шаардлагад нийцсэн гэж үзэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургуулийн номын сан нь эрдэм шинжилгээ, гадаад ном, бизнес мэдээлэл, тогтмол хэвлэл, гэрээр ном олгох үйлчилгээ зэрэг 5 фондтой, номын фонд нийт 67000 хэвлэмэл номтой, эрх зүйн хөтөлбөрийн суралцагчдын 75-85% нь

- дунджаас дээш үнэлгээ өгсөн нь суралцагчдын сэтгэл ханамжийн түвшин хангалттай гэж дүгнэгджээ.
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн номын сантай хамтран ажилладаг нь мэргэжлийн ном сурах бичгийн баяжилт хийхэд түлхэц болдог. Жил бүр номын сангийн баяжилт хийхдээ мэргэжлийн багш нарын саналыг үндэслэн комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг.
 - Номын сангийн танхим сандлын тоо, ном сурах бичгийн тоо нь стандарт шаардлагыг хангаж байна. “*Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага*”-ыг хангаж байна.
 - Тус сургуулийн номын сан нь бусад их дээд сургуулийн нэгэн адил номын сангийн lib4U программыг ашиглаж байгаагаас гадна EBSCO Discovery service цахим мэдээллийн санг 2009 оноос 12 дахь жилдээ авч ашиглаж байгаа бөгөөд лавлагаа, мэдээллийн нэгдсэн хайлтын системийн тусламжтайгаар СЭЗИС-ийн номын сан нь 139 төрлийн нэр бүхий мэдээллийн сангуудаас 428858 цахим ном, зохиол, сурах бичиг, тогтмол хэвлэл, эрдэм шинжилгээний сэтгүүл, өгүүлэл, илтгэл, судалгааны материалтай.24 цагийн турш орон зай, цаг хугацаа үл харгалзан цахим номын сангаар үйлчлүүлэх боломжийг Монгол улсын хэмжээнд анх удаа олгосон.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Программын шинэчлэлийг цаг тухай бүрт нь хийж ирсэн. Номын сангийн лавлагаа мэдээллийн EBSCO Discovery service хайлтын системийг суурилуулсан нь Монгол улсдаа анхдагч байсан нь сайшаалтай.
- 100 суудалтай ганцаарчилсан уншлагын танхимтай
- Судлаачдын өрөөг иж бүрэн тохижуулсан
- Цахим мэдээллийн санг баяжуулах дээр анхаарч ажиллаж байгаа бөгөөд сүүлийн 4 жилд 56,750,990-68,806,629 болтол үнийн дүнгээр цахим сангаа баяжуулсан байна.
- 2020-2021 оны хичээлийн жилд төгсөгчдийн UFE-APP–д суурилсан номын түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх төслийг хамтран хийж, удирдамж болон бусад ажлуудыг эхлүүлэн хэлэлцээрийн шатанд явж байна.
- Доктор, магистр, бакалаврын судалгааны ажил болон багш нарын бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэг нийт 2370 гаруй бүтээлийг бүрэн эхээр нь унших боломжтой бүтээлийн сантай болсон.

Анхаарах асуудал:

- Эрх зүйн мэргэжлийн чиглэлийн унших номын тоо бага

Шаардлага:

- Мэргэжлийн ном сурах бичиг, сэтгүүлийн тоог нэмэгдүүлэх
- Ном бүрдүүлэлтийн журамд нэмэлтээр цахим фонд үүсгэх зүйл заалт оруулах

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- СЭЗИС-ийн захирлын 2016 оны тушаалаар “Журам батлах, МЗХ-ны гишүүдийг томилох тухай” тушаал гарч “Мэргэжлийн зөвлөх хороо” байгуулжээ.
- Мэргэжлийн зөвлөл нь салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн судлаач, мэргэжлийн холбоод болон ажил олгогч байгууллагын төлөөллөөс бүрдэж байна. Тус зөвлөлийн гишүүдийн саналыг хүлээн авч сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн сайжруулсан байна. Гэвч Мэргэжлийн зөвлөл тогтсон хугацаандаа хуралдаж чадахгүй байх, хорооны гишүүдийн сонгуульт хугацаа /2 жил/ дуусах зэрэг хүндрэл тулгардаг тул нэгэнт сонгосон гишүүдийг ойрхон хугацаанд солих, дахин сонгох зэрэг нь хөтөлбөрийн шинэчлэл, боловсруулалтанд сөргөөр нөлөөлөхийг үгүйсгэхгүй.
- Эрдмийн зөвлөлийн дэргэд “Хөтөлбөрийн агуулга, арга зүйн хороо” ажиллуулсан ба “Сургалтын хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх, батлуулах журам”-г шинэчлэн боловсруулжээ. Эрх зүйн хөтөлбөрийн хороо байгуулаагүй.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөөг гаргадаггүй жил бүрийн үйл ажиллагааг жилээр төлөвлөдөг.
- Тус сургууль нь холбогдох хууль, журмын хүрээнд сургуулийн сургалтын онцлогт тохирсон дотоод дүрэм, журмаа боловсруулан ажиллаж байна.
- “Бакалаврын сургалт зохион байгуулах журам”-ын дагуу сургалтын хөтөлбөрөө боловсруулж, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.
- Энэ нь БШУ-ын Сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалын хавсралт “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын хүрээнд боловсруулагджээ.
- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой санал асуулгыг сургалтын үйл ажиллагаа, багш оюутан, ажилтан, тэдгээрийн ёс суртахууны холбоотой, сургалтын орчин, оюутанд үзүүлэх үйлчилгээ, хууль дүрэм журам хөдөлмөрийн харилцаатай хамааралтай, эрдэм шинжилгээ, судалгаатай холбоотой гэж ангилан боловсруулж, оюутан санал хүсэлтээ сургалтын мэдээллийн системээр шуурхай холбогдон илгээх боломж олгожээ. Харин тайланд тусгаснаар санал гомдлын мэдээллийг харахад зарим хичээлийн жил санал гомдол огт ирээгүй /2016-2017, 2018-2019 оны хичээлийн жилүүдэд/ 2020-2021 оны хичээлийн жилд 1 гомдол ирснийг хүлээн авч, шийдвэрлэсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Цахимаар сургуулийн удирдлага, багш, ажилтан, суралцагч, төгсөгч, эцэг, эхчүүд санал, гомдлыг ямар ч үед гаргах бүрэн боломжтой, ирсэн санал, гомдлыг 24-48

цагийн дотор харьяа салбар, нэгжид нь өгч шийдвэрлүүлэн хариуг мэдэгдэж хэвшсэн

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн зөвлөх хороог байгуулан ажиллаж байгаа боловч эрх зүйн хөтөлбөрийн дэд хороо байхгүй

Зөвлөмж:

- Мэргэжлийн зөвлөх хороог тогтмол ажиллуулж, саналыг хөтөлбөрт тусган ажиллах, мэргэжлийн зөвлөх хорооны бүрэн эрхийн хугацааг нэмэгдүүлэх
- Эрх зүйн хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Дотоодын болон бусад улс орны их дээд сургуулиуд, сургалт судалгааны байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан олон арван төсөл хөтөлбөрүүд амжилттай гүйцэтгэж иржээ.
- Сургалтын хөтөлбөрийн агуулгад шинэчлэл хийн Англи хэлний олон улсын EAP /English for academic purposes/ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь нийгмийн эрэлт, шаардлагад тулгуурлан хэрэгжүүлж буй чухал алхам гэж үнэлж байна.
- Гадаадын их дээд сургуульд мэргэжлийн багш нараас багш солилцоогоор ажиллуулах бүрэн боломжтой бөгөөд цаашид төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх боломжтой.
- оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжиж эхлээгүй байгааг анхаарах.
- 2015-2021 онуудад нийт 62 оюутан Ректорын нэрэмжит тэтгэлэг авсан нь нийт суралцагчдын 28%-ийг эзэлж байгаа ба сүүлийн жилүүдэд тогтмол өсөх хандлагатай байгаа нь оюутан суралцагчдын сурлагын амжилтанд тэтгэлэг бодитой нөлөөлж байгаа нь харагдаж байна.
- “Оюутны хөгжлийн зээл”-д тавигдах гол шалгуур нь сурлагын амжилт бөгөөд, тус хөтөлбөрийн 84 оюутан Оюутны хөгжлийн зээлд хамрагдсан нь нийт оюутнуудын 37%-ийг эзэлж байна.
- “МУ-ын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг”, “МУ-ын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг”, “Хаан банкны нэрэмжит тэтгэлэг” зэрэг дотоодын их дээд сургуулиудад зарлагддаг тэтгэлэг хөтөлбөрүүдэд тус сургуулийн Эрх зүйн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудад ч нээлттэй юм.
- Хөтөлбөрөөр суралцагч оюутнуудын Нийгмийн дадлагын тайлангаас харахад 85% нь сайн үйлсийн шинжтэй байгаа нь нэг талаас маш сайн боловч үүнийг үр дүнтэй, оюутанд мэргэжлийн талаас илүү үр өгөөжтэй байх чиглэлийг судалж болохыг санал болгож байна.
- Төгсөгчидтэй эргэх холбоотой байж тэднийг давтан сургах, ахисан түвшний сургалт зохион байгуулах ажлыг жил бүр хийж ирсэн байна. Нийт 80 төгсөгчийн 18-н

төгсөгч /22.5%/ нягтлан бодох бүртгэл мэргэжлээр, 4 төгсөгч /5%/ ахисан шатны буюу магистрын сургалтад хамрагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнуудаар нийгмийн дадлага хийж гүйцэтгүүлдэг бөгөөд эрүүл мэндийг дэмжих, байгаль орчныг хамгаалах болон ЕБС-ийн сурагчид, өндөр настай иргэд, бага насны хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зорилтот бүлэгт чиглэсэн ажлуудыг хийжээ. Энэхүү нийгмийн дадлага ажлын хүрээнд оюутнууд нийгэмд хамгийн их тусламж, хэрэгцээ шаардлагатай байгаа иргэдэд тусалж, тэдний амьдралд бага ч болов эерэг өөрчлөлт, үр нөлөөг бий болгож, өөрийн мэддэг чаддаг зүйлсээ бусдад зааж, суралцуулахын сацуу байгаль орчиндоо ч мөн адил хувь нэмрээ оруулжээ. Уг ажлыг хийж гүйцэтгэснээрээ оюутнуудын аливааг зохион байгуулах, түүнийгээ гүйцэтгэх болоод бусадтай харилцах, тэдэнтэй ойлголцох ур чадвар гээд хувь хүний хөгжилд ихээхэн ахиц дэвшил гарч, бусдыг хайрлах, энэрэх, хүндлэх, аливаа зүйлд хүнлэг энэрэнгүй сэтгэлээр хандахад суралцуулдаг байна.

Зөвлөмж:

- Давтан сургах, сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгох, тэднийг дэмжих, тодорхой журам одоогоор гараагүй байгааг анхаарч яаралтай журамлах хэрэгтэй.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Элсэгчдийн тоо жилээс жилд өсч хөтөлбөрийн орлого тогтмол өсч байгаа хэдий ч зөвхөн сургалтын төлбөрөөр санжүүжилтээ бүрдүүлдэг тул контент бүтээх худалдах, зах зээлд нийлүүлэх, ном хэвлэл хэвлүүлэн борлуулах, дотоод гадаадын төрийн болон бусад байгууллагатай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэтээр санхүүжилтийн олон боломжит суваг нээх шаардлагатай.
- Хөтөлбөрийн нэг суралцагчид ногдох өртөг зардал өсөхгүй байгаа нь инфляцийн түвшинтэй харьцуулахад нэмэх шаардлагатайг харуулж байна.
- Харин эрх зүйн хөтөлбөрийн нийт орлого, зардлын харьцааг харвал хөтөлбөр анх эхлэхэд /2015-2016/ нийт төлбөрийн 86% нь хөтөлбөрт зарцуулагдаж байсан бол тайлант хугацааны эцэст /2019-2020/ 31% хүртэл жил бүр буурчээ. Гэхдээ ном сурах бичиг, сургалттай холбоотой зардал тогтмол өссөн нь сайшаалтай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Сүүлийн 5 жилд эрх зүйн тэнхимийн багшийн хөгжлийг дэмжихэд 5 061 500 төгрөг зарцуулсан нь шинээр хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа сургуулийн хувьд хангалтгүй байна.

Зөвлөмж:

- Багшийн хөгжлийг дэмжих, мэргэшүүлэх болон давтан сургах үйл ажиллагаанд гарах зардлыг нэмэгдүүлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Эрх зүйн хөтөлбөр нь харьцангуй шинэ хөтөлбөр тул СЭЗИС-ийн бусад хөтөлбөрүүдээс нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байдал, мэргэжлийн багш нарын олон жилийн дадлага туршлага, төгсөгчдийн зах зээл дэх байр суурь, ажлын байрны эрэлт зэрэг хүчин зүйлээрээ онцлог, ялгаатай.
- Хөтөлбөрийн талаарх мэдээ, мэдээллийг цаг алдалгүй гадаад, дотоод орчинд тогтмол хүргэхэд сургуулийн үйл ажиллагаанд ашиглаж хэвшсэн албан, албан бус мэдээллийн суваг, системүүдийг ашиглахаас гадна оролцогч талуудад хөтөлбөрийн мэдээлэл хүргэх боломжтой үйл ажиллагаанд оролцох, арга хэмжээ зохион байгуулах зэргээр мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлдэг. СЭЗИС нь платформ, түншлэлийн албатай бөгөөд платформ, түншлэл, хамтын ажиллагаа хариуцсан проректор удирдах бөгөөд дараах чиг үүрэг бүхий мэргэжилтнүүд ажилладаг.
- Маркетингийн мэргэжилтэн, дижитал хөгжлийн зөвлөх, контент хөгжүүлэгч нарын ажлын чиг үүрэгт хөтөлбөрийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх чиг үүрэг байдаг. Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим мэдээллийн агуулгыг бэлтгэж өгөх үүрэгтэй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Жил бүрийн элсэлтийн үйл ажиллагааг олон төрлийн суваг ашиглан илүү үр дүнтэй болгох, бие даасан байдлаар сурталчилгаа, маркетингийн ажлыг удирдах зохион байгуулах нь зүйтэй.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Эрх зүйн тэнхмийн багш нар нь жил бүрийн 4 дүгээр сард мэргэжлийн холбогдолтой эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулдаг ба хурлын эмхэтгэлүүдийг хэвлүүлж, оюутнуудад хүргэдэг. Түүнээс өөрөөр одоогоор хэвлүүлсэн гарын авлага, сурах бичиг байхгүй байна. www.ufe.edu.mn сургуулийн веб сайтаар жилд ойролцоогоор 240 гаруй мэдээ, мэдээлэл нийтэд хүрч байгаагаас, Эрх зүйн тэнхим нь өөрийн цахим хуудсаараа мэдээ мэдээллийг нийтэд хүргэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУЯ-ны сайдын 2013 оны А/79 тоот тушаал, БСШУС-ын 2016 оны А/87, 2018 оны А/194 дугаар тушаалаар орсон нэмэлт өөрчлөлт оруулсан журмыг баримтлан СЭЗИС-ийн ректорын “Элсэлтийн нэгдсэн бодлого”, “Бодлого, журам, процесс батлах тухай”, “Бодлого, журам батлах тухай”, “Оюутан элсүүлэх журам” зэрэг тушаалууд гарган элсэлтийн үйл ажлыг зохион байгуулж байна.
- Оюутан элсүүлэх журмаа жил бүр шинэчлэн баталж ажиллаж байна. Элсэгчдэд мэдээллийг олон төрөл хэлбэрээр хангалттай өгч байна. Эрх зүйн хөтөлбөрт элсэхээр бүртгүүлсэн суралцагчдын тоо, элссэн суралцагчдын тоо, элссэн хувь, нийт элсэгчдийн дунд эрх зүйн хөтөлбөрт элсэгчдийн хувь хэмжээг сүүлийн 4 жилээр харьцуулан гаргасан байна.
- Шинэ элсэгчиддээ зориулсан мэдээлэл, чиглүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулдаг. Одоогоор эрх зүйн хөтөлбөрт гадаад оюутан элсээгүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэгчдэд ЭЕШ-ын онооны харьцангуй өндөр шаардлага тавьсан нь хөтөлбөрийн зорилгод сайн суралцагч элсэх нөхцлийг бүрдүүлсэн нь онцлог байв.

Анхаарах асуудал:

- Босго оноог 620 гэж заасан боловч эрх зүйн хөтөлбөрт элсэгчдийн дундаж оноо 600-дээш байгаа хэдий ч сургуулийн элсэлтийн журамд заасан босго онооны шалгуурт хүрэхгүй байгаа тул журмандаа нийгмийн тухай мэдлэг, математикаар ЭЕШ өгч байгаа бөгөөд аль нэг шалгалт нь 620 эсвэл хоёр шалгалтын дундаж оноо 620 хүрсэн байна гэж тодорхой зааж өгөх.

Зөвлөмж:

- Элсэгчдэд зориулсан хөтөлбөрийн танилцуулга, холбогдох дүрэм, журам, хичээлийн танилцуулгыг агуулсан элсэгчийн гарын авлага бэлтгэх.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Эрдэм, шинжилгээний хурлыг жил бүр зохион байгуулж, салбар хуралдаануудыг тогтмол явуулж хэвшсэн байна. Эрх зүйн тэнхмээс мэргэжлийн оюутнуудад чиглэсэн Business Law эрдэм шинжилгээний хурлыг тэнхимийн төлөвлөгөөндөө тусган зохион байгуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид үзүүлэх үйлчилгээ, болон сургалтын хөтөлбөр, бие даасан журам одоогоор байхгүй байна.

- 2009 онд “Боловсрол соёл шинжлэх ухааны яам” болон “Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам”-ны санжүүжилттэйгээр “*Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв*” байгуулагдан туршилтын дэд хөтөлбөр нь 2 жил үргэлжлээд 2012 онд зогсоход СЭЗИС нь энэхүү алба нэгжийг “Оюутанд үйлчлэх төв” болгон шинэчилсэн. 2018 он хүртэл тусдаа бие даасан нэгжийн зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж байгаад 2018-2019 оны хичээлийн жилд сургуулийн нэгдсэн бүтцийн өөрчлөлтийн дагуу бакалаврын сургалтын албатай нэгдэж 2 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.
- **СЭЗИС-ийн оюутны хөгжлийн бодлого** Оюутан нь курс ахих тусам сурч буй мэргэжлийн чиглэлээр мэдлэг, боловсрол нь өсөж байхаас гадна хувь хүний хөгжлийн хувьд ч өсөж дэвжиж байх шаардлагатай юм. СЭЗИС-ийн БСА нь оюутныг нийгмийн өмнө хариуцлага бүхий иргэн болж төлөвших, хувь хүний хөгжлийг дэмжих арга хэмжээг зохион байгуулж, дэмжиж ажиллах чиг үүрэгтэй.
- Оюутанд зөвлөх, хөгжүүлэх үйл ажиллагаа нь процессын зураглал, тухайн хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагааны календарьчилсан төлөвлөгөөний дагуу Бакалаврын сургалтын албаны оюутны хөгжил хариуцсан мэргэжилтэн болон ангийн зөвлөх багш нар хамтран зохион байгуулдаг. Хөтөлбөрийн хувьд мэргэжлийн ангийн оюутнуудад багаар ажиллах чадвар, мэргэжлийн ур чадвараа сайжруулах зорилгоор тэнхимийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ажлын байрны үзэсгэлэн, яармагийг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг нь оюутнууд болон төгсөгчдөд хөдөлмөр зуучлалын үйлчилгээ үзүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж байна. Энэ ажлын хүрээнд үндсэн ажилтнаар, цагийн болон гэрээт ажилтнаар, оюутнууд дадлагын ажлаа хийх нөхцөл, боломж бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Суралцагчдад сэтгэл зүйн зөвөлгөө туслалцаа үзүүлэх байдлыг тусгай мэргэжилтнээр өгдөг байхад анхаарах

Зөвлөмж:

- Одоогоор хөгжлийн бэрхшээлтэй суралцагч эрх зүйн хөтөлбөрт суралцаагүй байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид үзүүлэх үйлчилгээ, болон сургалтын хөтөлбөр, бие даасан журмыг боловсруулах.
- Мэргэжлийн болон олон нийтийн бусад байгууллагатай хамтран ажиллаж суралцагчдад хүргэх олон талын зөвлөмж, үйлчилгээ туслалцааг мэргэжлийн түвшинд хүргэх.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургууль дээр сайн дурын 23 клуб, дугуйлан үйл ажиллагаагаа явуулж, нийт 500 гаруй оюутан хамрагдаж байна.

- Эрх зүйн хөтөлбөрийн оюутнуудын Акси клуб 2016 онд байгуулагдан тэнхимийн багш нартайгаа хамтран ажиллаж байна.
- Оюутан, суралцагчдыг дэмжих, хөгжүүлэх зорилгоор сургалт, урлаг, спортын болон тэмдэглэлт өдөрлөг, эрдмийн баяр, шинэ жил гэх зэрэг үйл ажиллагаанд зориулсан төсөв баталдаг гэж тайланд тусгасан байна. Оюутны үйл ажиллагаанд зориулагдсан зардал жил бүр өсөлттэй байгаа нь сайшаалтай байна.
- Оюутнууд суралцахын зэрэгцээ нийгэмдээ чиглэсэн сайн үйлсийн аян, сайн дурын ажлуудыг зохион байгуулж байна.
- Тайлант хугацаанд эрх зүйн хөтөлбөрийн давхардсан тоогоор 383 оюутан 454,359,172 төгрөгийн тэтгэлэг, зээл, тусламж, хөнгөлөлт, шагналд хамрагдсан нь оюутнуудын хувьд санхүүгийн дэмжлэг авах боломж бүрдсэн байгааг харуулж байна. Сайн дурын ажлын үнэлгээ, урамшууллыг зохицуулсан журам байхгүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Тэтгэлэгт хамрагдах хэрэгцээ шаардлагыг бодитойгоор тодорхойлон суралцагчийн хамрагдах хүрээг нэмэгдүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Сайн дурын ажлын үнэлгээ, урамшууллыг зохицуулсан журамтай болох
- Сайн дурын ажлыг төгсөлтийн баримт бичигт тусган баталгаажуулж, өгч байх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- СЭЗИС-ийн ректорын 2019-03-14-ний өдрийн А/057 тоот тушаалаар баталсан Бакалаврын сургалт зохион байгуулах журмын 4 бүлэгт магадлан итгэмжлэгдсэн гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежид өдрийн үндсэн хэлбэрээр суралцаж буй болзол хангасан оюутан шилжин суралцах боломжтойг тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны хөтөлбөрөөс гадуурх сургалтын үр дүнг хөтөлбөрт багтаан дүйцүүлэх боломжтой болгож өгсөн нь сайн тал болсон байна.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Бакалаврын зэргийн сургалтыг амжилттай дүүргэн, мэргэжлийн бэлтгэлийн түвшинг дипломын төсөл хамгаалалтаар үнэлүүлэн зохих шаардлагуудыг хангасан

оюутанд дипломын төсөл хамгаалуулах комиссын шийдвэрийг үндэслэн мэргэжил, боловсролын зэрэг түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болох диплом, энгэрийн тэмдгийг ректорын тушаалаар олгодог. СЭЗИС-ийн дипломыг олгохдоо Монгол улсын Боловсролын тухай хууль, дээд боловсролын тухай хууль, БСШУС-ын 2002 оны 355-р тушаалын заалтыг үндэслэн олгодог.

- Санхүү, эдийн засгийн их сургууль анх 2018 оноос блокчейн технологид суурилсан диплом баталгаажуулах санаачлагыг Бүгд Найрамдах Кипр Улсын Никосиагийн их сургуультай хамтран эхлүүлсэн бөгөөд 2018 оны 10 дугаар сард хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулсан. Улмаар 2019 оны 11 дүгээр сард тус сургуулийн дэргэдэх Блокко компани (www.block.co) -тай хамтран анхны блокчейн технологид суурилсан дипломыг олгож эхэлсэн. Блокко компани нь Кипр улсын технологи хөгжүүлэлтийн компани бөгөөд блокчейн технологийн хөгжүүлэлт, сургалт, технологи дамжуулалтын үйл ажиллагаа явуулдаг.
- Блокчэйн нь мэдээллийг найдвартай хадгалж, хуваалцах боломж олгодгоороо маш давуу талтай. Блокчэйнээр баталгаажсан диплом авснаар дипломоо хэн нэгэнд нотлох шаардлагагүй болно.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2018 оноос блокчейн технологид суурилсан диплом баталгаажуулах санаачилгыг Бүгд найрамдах Кипр улсын Никосиагийн их сургуультай хамтран эхлүүлсэн бөгөөд 2019 оноос эхлэн блокчейн технологид суурилсан дипломыг олгож эхэлсэн байна.
- Гадаадад сурах гэж буй оюутнууд дипломоо нотариатаар баталгаажуулаад, орчуулгын товчоогоор оруулан, Гадаад харилцааны яамны Консулын газраас баталгаажуулж, олон улсын дипломын хөндлөнгийн үнэлгээ хийлгэх зэрэг ажлуудыг сургуулийн вэбсайт руу ороод хэдхэн хормын дотор баталгаажуулахаар хөнгөвчилжээ.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- СЭЗИС-ийн захирлын 2015-1-19-ний өдрийн 039 тоот тушаалаар батлагдсан СЭЗИС-ийн Дотоод журам, Багшийн хөдөлмөр түүнийг үнэлэх, дүгнэх журам, Багш, ажилтны сонгон шалгаруулалт, ажилд томилох, чөлөөлөх процессын зураглалд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.
- Эрх зүйн тэнхимд 2021-2022 оны хичээлийн жилийн байдлаар үндсэн 12 багш 1 туслах ажилтны орон тоотойгоор ажиллаж байна. Захиргааны албаны дарга

хуульч, өмгөөлөгч С.Батбуян, салбар дундын судлалын тэнхимийн багш доктор Ж.Оюунтунгалаг нар хичээл заадаг. Нийт эрх зүйн үндсэн 12 багш, цагийн болон гэрээт 6 багштай.

- Үндсэн 10 багшийн 20%, эрх зүйн 12 багшийн 25% доктор зэрэгтэй бусад нь магистр зэрэгтэй.
- 30% - СЭЗИС-ийн дэд профессор
- 40% - СЭЗИС-ийн ахлах багш
- 20% - СЭЗИС-ийн багш
- 10% - СЭЗИС-ийн дадлагажигч багш зэрэглэл дээр ажиллаж байна.

Багш нар:

- 100% Хуульчийн гэрчилгээтэй
- 50% Хуульчийн болон Өмгөөллийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй
- Шанхайн Олон Улсын Худалдаа Эдийн засгийн Арбитрын комиссын арбитрч /эвлэрүүлэн зуучлагч, МҮХАҮТ-ын дэргэдэх ОУ-ын арбитрын арбитрч -1
- Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч - 1
- Хууль зүйн орчуулга хийх эрх - 2
- Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх эрх- 2
- Компанийн засаглалын гэрчилгээтэй багш- 1
- 5 докторантурт сурч байгаа багштай

Багш нарын судалгааг дараах хүснэгтээр харуулав

Хүснэгт 1. Үндсэн багш нарын мэдээлэл

№	Багшийн нэр	СЭЗИС-ийн албан тушаалын зэрэглэл	Бакалавр төгссөн сургууль	Магистр төгссөн сургууль	Докторт суралцсан сургууль	Докторын зэрэг хамгаалсан сэдэв	Боловсорлын салбарт ажилласан жил	СЭЗИС-д багшаар ажилласан жил
1	Д.Оюун	Дэд профессор	1994-1996 МУИС-ХЗДС БНХАУ-ын Шандуны их сургууль 2001 он	МУИС-ийн ХЗДС 2004	Докторантурын хичээлээ дүүргэсэн		21 жил	21 жил
2	Б.Дэлгэрмаа	Дэд профессор	Шихихутуг ХЗДС 1997	МУИС-ийн ХЗДС 1999	Докторантурын хичээлээ дүүргэсэн		24 жил	24 жил
3	Ж.Хулан	Дэд профессор	Шихихутуг ХЗДС 1997	МУИС-ийн ХЗДС 1999			23 жил	23 жил
4	Л.Хаш	Ахлах багш	ИЗИС 2007	ИЗИС 2009	БНХАУ-н ӨМИС 2016	МУ болон БНХАУ-ын ялын бодлогын харьцуулсан судлал	8 жил	8 жил

5	Б.Мөнгөнахиа	Ахлах багш	ИЗИС 2007	ИЗИС 2009	Докторан-турын хичээлээ дүүргэсэн		5 жил	9 жил
6	О.Одзаяа	Дадлага-жигч багш	БНХАУ-н Далианы ИС, ХЗС 2013	МУИС-ийн ХЗС 2018			3 жил	3 жил
7	Л.Отгонбаяр	Ахлах багш	ХСИС 2004	ИБУИНВУ, Эдинбургийн их сургууль 2013	Докторан-турын хичээлээ дүүргэсэн		3 жил	3 жил
8	Э.Баярмаа	Багш	МУИС-ийн ХЗС 2011	Япон улсын Кюшүгийн ИС, ХЗС 2020			1 жил	1 жил
9	Э.Гэрэл	Багш	МУИС-ийн ХЗС 2007	БНЭУ Майсуурь их сургууль ХЗС 2014	Докторан-турын хичээлээ дүүргэсэн		1 жил	1 жил
10	С.Энхбаяр	Ахлах багш	Цагдаагийн академи 2004	Цагдаагийн академи 2006	Хууль зүйн дотоод хэргийн их сургууль 2016	Аж ахуйн үйл ажиллагааны улсын бүртгэл, тусгай зөвшөөрлийн зарим асуудал	10 жил	2 сар
11	С.Батбуян	Ахлах багш	Шихихутуг ХЗДС 2008	Шихихутуг ХЗДС 2009	Докторан-турын хичээлээ дүүргэсэн		14 жил	9 жил
12	Ж.Оюунтунгалаг	Дэд профессор	Эрхүүгийн их сургууль 1996	МУИС-ийн ХЗС 2002	Япон улсын Касая ИС, ХЗС 2010	Итгэл эвдэж хөрөнгөжихийн эсрэг иргэний эрх зүйн харьцуулалт	7 жил	2 жил

- Багшийн хөдөлмөр түүнийг үнэлэх, дүгнэх журам, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн үзэсгэлэн зохион байгуулах, шилдэг тэнхим, баг, багш, Шилдэг энтрепренер бүтээл шалгаруулах удирдамж, багш ажилтнуудын цалин хөлс, шагнал, урамшуулал, хөнгөлөлт, хангамжийн журам, багш ажилтнуудыг шагналд тодорхойлох, шагнал олгох зааврын дагуу багш нарыг урамшуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Элсэгчийн тоо жил ирэх тутам өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор үндсэн багшийн тоог нэмэгдүүлэх,

- Ажилтныг сургах, хөгжүүлэх ажил төлөвлөгөө гаргасан хэмжээнд байгааг цаашид анхааран, ажлын байранд тасралтгүй хөгжүүлэх, хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлэдэг байхад анхаарч ажиллах нь зүйтэй.
- Докторантурын сургалтаа дүүргэсэн багш нарын докторын зэргээ хамгаалах ажилд нь сургуулийн зүгээс дэмжлэг үзүүлэх

Зөвлөмж:

- Багшлах бүрэлдэхүүний нөөцөд авагдсан судлаач, мэргэжилтний сан үүсгэх, судлах,
- Залуу үеийн багшлах бүрэлдэхүүнийг шинжлэх ухааны тодорхой судалгааны чиглэлээр мэргэшүүлэх, эрдмийн зэрэг хамгаалах үйл ажиллагааг эрчимжүүлэх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш хөгжлийн хүрээнд төрөөс баримтлах бодлого, эрх зүйн зохицуулалтын зорилгод нийцүүлэн Багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.
- Багшийг цахим орчинд хөгжүүлэхэд ихээхэн анхаарч ажилласан нь баримтаар тогтоогдож байна.
- СЭЗИС-аас нэгдсэн хэлбэрээр багшийн хөгжлийн сургалт, семинар, уулзалтуудыг зохион байгуулдаг бөгөөд эдгээр сургалтуудад эрх зүйн тэнхимийн багш нар хамрагдаж, заах арга зүй болон орчин үеийн чиг хандлагын талаарх мэдээ, мэдээлэл, мэдлэг, туршлагыг олж авдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийг цахим сургалтын орчинд хөгжүүлэх ажил нь үр дүнтэй, туршлага болохоор байна.

Анхаарах асуудал:

- Багшийг хөгжүүлэх санхүүжилтийг нэмэгдүүлэх, жилийн төсөвт тодорхой төлөвлөлтөөр тусган, зарцуулах ажлыг тогтмолжуулах шаардлагатай.

Зөвлөмж:

- Багшийг хөгжүүлэх, давтан, мэргэшүүлэх сургалтыг тогтмол төлөвлөгөөнд тусган зохион байгуулах
- Гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг сургуулиудад багш нараа явуулж туршлага судлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийлгэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тайлант хугацаанд сургуулийн болон гадны байгууллагын санхүүжилттэй 12 төсөлд давхардсан тоогоор эрх зүйн тэнхимийн 16 багш оролцсон байна.
- Эрх зүйн тэнхимийн багш, судлаачдын хийсэн эрдмийн ажлыг Боерын загвараар гаргасан бөгөөд хэрэглээний чиглэл, нэгтгэн уялдуулах, сургалтын чиглэлээр ажлууд хийгдсэн бөгөөд нээлт хийх, олж илрүүлэх, эрдмийн ажлууд хийгдээгүй байна.
- Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлэн СЭЗИС-ийн ректорын тушаалаар баталсан дүрэм, журмуудаар зохицуулж байна.
- Эрх зүйн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа эрх зүйн тэнхимийн багш нар хянан магадлагаатай Эрдэм шинжилгээний хурал, семинарын эмхтгэлд бүтээлээ хэвлүүлэх, илтгэл хэлэлцүүлэх ажлуудыг түлхүү хийдэг болох нь харагдаж байна.
- Тайланд эрдэм шинжилгээний хуралд 15 сая төгрөг, судалгааны төсөлт ажилд 2018 дуустал 48-141 сая төгрөг, багшийн хөгжилд 90 гаруй сая төгрөг төсөвлөдөг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Багшийн судалгааны ажлыг санхүүжүүлэх нөөц, бүрдүүлэлт хангалтгүй байна. Зөвхөн сургуулийн санхүүгийн дотоод эх үүсвэрийг ашиглахаар хязгаарлагдахгүй хөрөнгө оруулалтуудыг татах санхүүгийн менежмент эрх зүйн тэнхим дээрээ хийх.
- Сэтгүүлд нийтлүүлж байгаа өгүүллийг мэргэжлийн түвшинд хянагддаг байх нөхцлийг байнга бүрдүүлж байх

Зөвлөмж:

- Төсөлд суурилсан сургалтын арга зүйг нэвтрүүлэх, гадаадын төсөл, хөтөлбөрийг сургалт, судалгааны ажилд татан оруулах.
- Судалгааны ажил, төсөлд оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор дотоод төслийн санхүүжилтийн нөөцийг бүрдүүлэх боломжийг судлах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөдөлмөрийг үнэлэхдээ СЭЗИС-ийн ректорын 2018-02-13-ны өдрийн А/051 тоот тушаалаар баталсан Багшийн хөдөлмөр түүнийг үнэлэх, дүгнэх журам болон түүний нэмэлт өөрчлөлтийн 8.5-д заасны дагуу хичээлийн жилийн улирал, болон бүтэн жилээр гүйцэтгэлийг холбогдох албан тушаалтнууд үнэлнэ. Энэхүү процессыг удирдлагын мэдээллийн системээр дамжуулан хийдэг.
- 2018-2019 оны хичээлийн жилээс Хүний нөөцийн бодлогын баримт бичиг баталсан ба энэхүү баримт бичигт багш, ажилтны албан тушаалын зэрэг, дэв, сургалт, карьер хөгжил, цалин шагнал, урамшуулал, хөнгөлөлт, хангамж, ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний талаар баримтлах бодлого, зохицуулалтуудыг тусгаж өгсөн байна.

- Тэнхимийн эрхлэгч, бакалаврын сургалтын алба, ахисан түвшний сургалтын албууд жилд нэг удаа чанарын үнэлгээ хийдэг байна. Багш бүр өөрийн заадаг хичээлээр Сургалтын багц материалын минимум стандартын дагуу бэлтгэсэн хавтастай болсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрх зүй бакалаврын хөтөлбөрийн бүрэлдэхүүнд, сургах арга зүйн төлөвлөлт, тэдгээрийг хүргэх хэлбэрийг иж бүрнээр тодорхойлсон бөгөөд сургалтын арга зүйн хэд хэдэн хэлбэрийг хэрэгжүүлэхээр заасан байв. Жишээ нь кэйсид суурилсан сургалт, сорилтод суурилсан сургалт, дадлагын орчинд суралцах арга зэргийг хэрэглэдэг талаар дурдсан нь уламжлалт хичээл заах аргаас татгалзаж, оюутны оролцоог нэмэгдүүлэх, илүү интерактив аргыг нэвтрүүлэхийг зорьсон нь харагдаж байна.

Зөвлөмж:

- Гадаад орны ижил түвшний сургалтын арга зүйг харьцуулан судалж, хичээл явуулах хэлбэрийг сонгохдоо судалгааны их сургууль байх зорилгодоо үндэслэж, илүү эрдэм шинжилгээний бүтээлийг судлах, хууль зүйн шинжлэх ухааны тулгамдсан асуудлыг гаргаж ирэх, үнэлэх, анализ хийх ур чадвар олгоход чиглэсэн аргыг ашиглах нь зүйтэй

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрт оролцогч талууд болох Эрдмийн зөвлөл, хөтөлбөрийн агуулга, арга зүйн хороо, эрдэмтэн багш нар, оюутан, эцэг эх, төгсөгчид, мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангах чиглэлээр оюутны сэтгэл ханамжийн судалгаа, оюутнуудыг хөндлөнгийн шалгалтанд хамруулах, төгсөгчдөөс асуулгын аргаар судалгаа авч, судалгааны үр дүнд шинжилгээ хийн үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.
- СЭЗИС-д чанарын баталгаажуулалтын ажилтан 2012 оноос эхлэн ажиллаж эхэлсэн, чанарын бие даасан алба байгуулагдаагүй боловч бүх тэнхим, алба нэгжийн төлөөлөл чанарын үйл ажиллагаанд жигд оролцож байдаг онцлогтой.
- 2018 оноос чанарын баталгаажуулалтын асуудал дээр сургуулийн зүгээс ихээхэн анхаарал хандуулж Сургалтын үр дүнгийн шинжээч, Сургалтын үйл ажиллагааны

шинжээч гэсэн хоёр мэргэжилтэнтэй болж ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан сургалтын чанарын баталгаажуулалтын ажлыг хийж ирсэн.

- СЭЗИС-ийн Ректорын тушаалаар Инноваци хөгжлийн газар 2020 онд байгуулагдсан бөгөөд чиг үүрэг дотор нь чанарын баталгаажуулалтын чиг үүрэг багтдаг.
- ACBSP-ийн олон улсын магадлан итгэмжлэлийн хүрээнд төлөвшүүлсэн Хичээлийн болон хөтөлбөрийн гарц үр дүнгийн шинжилгээ хийдэг, холбогдох удирдамж, журамтай /хичээлийн баг, мэргэжлийн баг, хөтөлбөр, бакалаврын сургалт, судалгааны алба, Ректорын зөвлөл/
- Peregrine академик сервисийн хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг магистр, бакалаврын мэргэжлийн бүх хөтөлбөрийн төлөөллийг оролцуулан 2015 оноос эхлэн жил бүр зохион байгуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Peregrine академик сервисийн хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг магистр, бакалаврын мэргэжлийн бүх хөтөлбөрийн төлөөллийг оролцуулан 2015 оноос эхлэн жил бүр зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- СЭЗИС нь хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлж чадсан боловч чанарын нэгдсэн бодлого, систем, стандартууд бүрэн бус үр дүнгийн тайлагнал тогтворжоогүй байна.

Зөвлөмж:

- 2015 оноос хойш ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг аваагүй байгаа нь төгсөгчид ажлын байран дээр ямар байгаа цаашлаад хөтөлбөр сайжруулахад гол хүчин зүйл болдог учраас энэ судалгааг тогтмол хийж хэвших хэрэгтэй байна.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- 2013 оноос хойш төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг оюутанд үйлчлэх төвөөс жил бүр тогтмол авч ирсэн. Судалгаанд бакалаврын хөтөлбөрийг тухайн жилд төгссөн төгсөгчдийн 80-аас дээш хувийг хамруулдаг.
- 2019-2020 оны хичээлийн жилийн нийт судалгаанд хамрагдсан төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдлыг харахад төгсөгчдийн 84% ажил эрхэлж байгаа бөгөөд тэдний 88% нь өөрийн төгссөн мэргэжлээрээ ажиллаж байгаа гэсэн судалгаа гарсан байна. Эрх зүй хөтөлбөрөөр төгсөгчдийн 88,2% нь мэргэжлээрээ ажиллаж байна.
- Төгсөгчдөөс ажил эрхлэлтийн судалгаанаас гадна хөдөлмөр эрхлэлтийн тогтвор, суурьшил, төгссөнөөсөө хойш ажилд орсон хугацааны судалгааг харахад ажилд орох дундаж хугацаа 2-3 сар байгаа бөгөөд энэ хугацаа жил ирэх тусам багасаж байгаа нь сайн үзүүлэлт гэж харж байна.

- Хөтөлбөрийн гарц үр дүнг хичээлийн жилд 1 удаа үнэлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Төгсөгчдөө хуульчийн сонгон шалгаруулалт болон ахисан түвшний сургалтанд бэлтгэн оролцуулах давтан сургалтуудыг зохион байгуулах.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- СЭЗИС нь анх 2008 онд АНУ-ын Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын байгууллага болох ACBSP гишүүнээр элсэж, 2012-05-01-ний өдөр олон улсад магадлан итгэмжлэгдсэн. Мөн бакалаврын зэрэг олгох 7 хөтөлбөр, магистрын зэрэг олгох 3 хөтөлбөр олон улсад магадлан итгэмжлүүлсэн байна.
- Эрх зүйн хөтөлбөрөөр 2018 онд анхны төгсөлтөө хийсэн бөгөөд хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу мэргэжлээрээ 2 жил ажилласны дараа хуульчийн сонгон шалгаруулалтанд орох эрх үүсдэг энэ жил анхны төгсөгчдийн нэг болох Г.Болормаа 2020-10-20-ны сонгон шалгаруулалтанд тэнцэж, хуульчийн гэрчилгээ авсан байна.
- Дотоодын болон олон улсын мэргэжлийн зэрэг, гэрчилгээ авдаг байгууллагуудтай хамтран ажилладаггүй учир мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрсөн мэргэжлийн зэрэг, гэрчилгээ авсан төгсөгчид цөөн мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах тал дээр сул. Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь гараагүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2008 онд АНУ-ын Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын байгууллага болох ACBSP гишүүнээр элссэж, 2012-05-01-ний өдөр олон улсад магадлан итгэмжлэгдсэн. Мөн бакалаврын зэрэг олгох 7 хөтөлбөр, магистрын зэрэг олгох 3 хөтөлбөр олон улсад магадлан итгэмжлүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогч эздийн холбоо болон бусад мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах тал дээр анхаарч ажиллах

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2	3.3		Номын сан мэдээлийн эх үүсвэр
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			
6	Багшийн үйл ажиллагаа	4			
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	3			
Бүгд		25	1		
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Санхүү эдийн засгийн их сургуулийн “Эрх зүй” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул шалгуурыг “Бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрх зүй чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг /С.Оюунбилэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Ш.Ариунбилэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /М.Сувд/

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Эрх зүйн хөтөлбөрийн дэд хороо байгуулж, хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлээ хийдэг тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай
2. Мэргэжлийн болон олон нийтийн бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, суралцагчдад хүргэх олон талын зөвлөмж, үйлчилгээ, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт судлаач оюутан, багш нарыг оролцуулж, судалгааны үр дүнг нэвтрүүлэх боломжийг судлах
3. Төсөл болон байгууллагын захиалгат судалгааны ажлын сэдэвт тулгуурлан багш нар гадаад дотоодын төсөл, санхүүжилт татах боломжийг эрэлхийлэх
4. Багшлах бүрэлдэхүүний нөөцөд авагдсан судлаач, мэргэжилтний сан үүсгэх, багшлах бүрэлдэхүүнийг шинжлэх ухааны тодорхой судалгааны чиглэлээр мэргэшүүлэх, эрдмийн зэрэг хамгаалах үйл ажиллагааг эрчимжүүлэх
5. Эдийн засгийн эрх зүй, банкны эрх зүй, санхүүгийн эрх зүй, үнэт цаасны эрх зүй, худалдааны эрх зүй гэх мэт салбар эрх зүйн хичээлүүдийг заавал судлах мэргэшүүлэх чиглэлийн хичээл болгон хөтөлбөрийн шинэчлэл хийх, мөн багшлах бүрэлдэхүүнийг эдгээр чиглэлээр хөгжүүлэх.
6. Одоогоор хөгжлийн бэрхшээлтэй суралцагч эрх зүйн хөтөлбөрт суралцаагүй байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид үзүүлэх үйлчилгээ, болон сургалтын хөтөлбөр, бие даасан журмыг боловсруулах.
7. Төгсөгчид ажлын байран дээр ямар байгаа цаашлаад хөтөлбөр сайжруулахад гол хүчин зүйл болдог Ажил олгогчдоос авдаг сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж хэвшүүлэх
8. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний ахиц, дэвшлийн тайланг жил бүр боловсруулж хэвших

V. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Ж.Хулан	Ахлах багш	Дэд профессор	23	Иргэний эрх зүй-1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрх зүй
2	Б.Дэлгэрмаа	Ахлах багш	Дэд профессор	24	Монголын төр, эрх зүйн түүх, Эрх зүйн онол, Төрийн онол
3	Л.Отгонбаяр	Ахлах багш		3	Үнэт цаасны эрх зүй, Өрсөлдөөн ба инновацын эрх зүй
4	Л.Хаш	Ахлах багш	Доктор Ph.D	8	Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн процессын эрх зүй, Шийдвэр гүйцэтгэлийн эрх зүй
5	С.Энхбаяр	Ахлах багш	Доктор Ph.D	1	Иргэний эрх зүй, Хувийн эрх зүйн хууль тогтоомжийн хэрэглээ
6	Э.Баярмаа	Багш	Магистр	1	Захиргааны эрх зүй, захиргааны процессын эрх зүй, Экологийн эрх зүй

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	П.Отгонцэцэг	4	Орон нутгаас
2	Т.Энхжин	4	Голч дүнгээр
3	Ц.Мишээл	4	Голч дүнгээр
4	Б.Энхжин	3	Голч дүнгээр
5	Т.Саранцацрал	3	Голч дүнгээр
6	Б.Марал	2	Лантуун дохио ТББ гишүүн
7	Б.Рэгзэдмаа	2	Орон нутгаас
8	А.Анулан	2	Нийгмийн идэвх
9	Б.Энхжин	2	Оюутны байр
10	О.Сумъяабазар	1	Шинэ элсэгч

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	М.Шинэбаяр	МҮХАҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитр	Ерөнхий нарийн бичгийн дарга
2	Б.Тунгалагнаран	Өмгөөллийн Эф-Би-Эл- Си ХХН	Захирал
3	Б.Батсэлэнгэ	Өмгөөллийн Легал Линк Си Би Эй ХХН	Захирал
4	Э.Анударь	УИХ-ын ТГ	УИХ-ын гишүүний зөвлөх
5	Л.Пагамсүрэн	Эм-Си-Эс Холдин ХХК	Ахлах хуульч
6	Н.Энхтуяа	Санхүүгийн зохицуулах хороо	Газрын дарга
7	Д.Алтангэрэл	Нэт Капитал ББСБ	ТУЗ-ын дарга
8	В.Энхтамир	ХЗҮХүрээлэн	Хэлтсийн дарга

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Ч.Болормаа	2018	ХЗҮХүрээлэн	Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн ажилтан
2	О.Саруулчимэг	2018	ZSB капитал ББСБ	Ахлах мэргэжилтэн
3	Ц.Булган	2018	Эрдэнэс таван толгой ХК	Мэргэжилтэн
4	Т.Ууганбаяр	2019	Сэлэнгэ аймаг Ерөө сум ИХ-ын ажлын алба	Архив, бичиг хэргийн ажилтан
5	М.Жавхлантөгс	2019	REMAX үл хөдлөх, зуучлалын компани	Агент
6	И.Халиунаа	2020	MCS холдинг ХХК	Нийцлийн ажилтан
7	Б.Сондор	2020	Олон улсын арбитр	Нарийн бичгийн дарга
8	А.Билгүүн	2020	УИХ-ын ТГ	УИХ-ын гишүүний туслах
9	Х.Оюунсанаа	2021	FBLC ХХН	Өмгөөлөгчийн туслах

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН
ИХ СУРГУУЛЬ**

13381 ш/х-49, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 5, Утас/Факс: (976-11) 45 83 78,
И-мэйл: info@ufe.edu.mn, Вэбсайт: www.ufe.edu.mn

2021.12.30 № 4/659
танай _____-ны № _____-т

БМИҮЗ-ИЙН ДЭД ДАРГА,
АЖЛЫН АЛБАНЫ ЗАХИРАЛ
О.ЯНЖМАА ТАНАА

СЭЗИС-ийн “Эрх зүйн бакалаврын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн багийн тайлан”-г хүлээн авч танилцлаа. Тайланд тусгагдсан дүгнэлт, зөвлөмж, анхааруулга нь хөтөлбөрийн цаашдын хөгжилд үнэтэй хувь нэмэр болно гэж өөрийн үнэлгээний тайлан бичсэн баг, хамт олон талархан хүлээн авч байна. Бид шинжээчийн багийн тайлан, дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байгаа ба цаашдын сургалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор төлөвлөгөөнд тусган ажиллах болно.

СЭЗИС-ийн эрх зүй хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан 2020-2021 оны хичээлийн жилээр дуусгавар болгож бичсэн бөгөөд тайлант хугацаанаас хойш анхаарах асуудалд тусгагдсан зүйлүүд хийгдэж байна. Шинжээчдийн тайланд тусгагдсан дараах хэсгүүд дээр нэмэлт тайлбарыг хавсралтаар явуулж байгааг хүлээн авна уу.

Тухайлбал тайлангийн **Шалгуур 3.3 Номын сан мэдээллийн эх үүсвэр. Хуудас 14-** д бичсэн дараах хэсгийг зөвлөмж болгох боломжтой эсэхийг нягталж өгнө үү.

Шаардлага:

- Мэргэжлийн ном сурах бичиг, сэтгүүлийн тоог нэмэгдүүлэх
- Ном бүрдүүлэлтийн журамд нэмэлтээр цахим фонд үүсгэх зүйл заалт оруулах

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн хамт олон, шинжээчийн багийн гишүүдэд амжилт хүсье.

Ажлын хэсгийн ахлагч:

СЭЗИС-ийн БАКАЛАВРЫН СУРГАЛТ, СУДАЛГАА ХАРИУЦСАН

ПРОРЕКТОР



Б.МӨНХЗАЯА (Ph.D)